



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/32

Баян-Өндөр сум

**Арга хэмжээ зохион байгуулж, хөрөнгө
гаргах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дахь заалт, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөрөнгө гаргах тухай” А/221 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хэмжээнд донорын эгнээг өргөжүүлэх, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэх, донор элсүүлэх ажлыг эрчимжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх чиглэлээр “Цусаа өгч, итгэл түгээе – Хамтдаа амьдрал бэлэглэе” уриа дор зохион байгуулах аяны удирдамжийг нэгдүгээр, аян зохион байгуулагдахад шаардлагатай төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг мөрдөж аяныг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн (А.Хонгорзул), Бүсийн Оношилгоо Эмчилгээний Төвийн Цусны салбар төв (С.Уранчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Шаардлагатай 10,000,000 /Арван сая/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (П.Хишгээ)-д даалгасугай.

ДАРГА

Ц.МӨНХЦЭЦЭГ





“ЦУСАА ӨГЧ, ИТГЭЛ ТҮГЭЭЕ- ХАМТДАА АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЕ”

АЯНЫ УДИРДАМЖ

Нэг: Зорилго

1. Цусны донорын талаарх мэдээллээр хангах, сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, донор элслүүлэх ажлыг төрийн болон төрийн өмчит байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудыг хамруулан зохион байгуулж шинээр цусны доноруудын тоог нэмэгдүүлэх.

2. Монгол Улсын төрөөс “Донорын цус цусан бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэгцээ хангамжийг сайжруулах, яаралтай тусламжийн үеийн нөөцийг бүрдүүлэх, гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх.

3. Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор байнгын донорыг хадгалах идэвх санаачилгыг өрнүүлэх, байнгын доноруудыг алдаршуулах, урамшуулах

4. “Цусаа өгч, итгэл түгээе-хамтдаа амьдрал бэлэглэе” уриан дор сайн дураараа цусаа өгч бусдын амьдралыг аврагч болохын чухлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан, хүн амын эрсдэл багатай бүлгээс сайн дурын авлагагүй донор сонгох, тэдгээрийг урамшуулах, цусаа өгөхийн ач холбогдол цусны донорын үйлсийг сурталчлахад оршино.

Хоёр: Зохион байгуулалт

Аян зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн

2. ЭМГ-ын хариуцсан мэргэжилтэн

3. БОЭТ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, цус сэлбэлтийг зохицуулах зөвлөлийн дарга

4. БОЭТ-ийн Цусны салбар төв

5. Орхон аймгийн УЗХ, УЗХ дэргэдэх донорын зөвлөл

Гурав: Аяны хугацаа

2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл

Дөрөв: Аяныг дүгнэх

1. Байгууллагынхаа нийт ажилчдын 70-аас доошгүй хувийг цус цусан бүтээгдэхүүний болон донорын талаарх сургалтад хамруулсан байх.

2. Байгууллага дээрээ 3-аас доошгүй байнгын донортой болж донороо хадгалах тодорхой ажлыг зохион байгуулахаар төлөвлөгөө гаргаж тушаалаар баталгаажуулсан байх.

3. Байгууллагын эрүүл мэндийн самбартай болж, шинэ доноруудыг хадгалах, улмаар байнгын донортой болох зорилгоор тухайн байгууллагын 1 ажилтан донорын сайн дурын сургагч багшаар бэлтгэгдэнэ.

4. Байгууллага бүр сургагч багшаараа дамжуулан цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж хийсэн ажлын тайланг Ажлын хэсэгт ирүүлнэ.

5. Байнгын донор нь шаардлагатай үед хамгийн олон удаа цусаа хандивласан байх

6. Цус цусан бүтээгдэхүүний нөөц, хангалт, төрөл урьд оноос нэмэгдсэн байх

Тав. Аяны болзол, тайлан

Донор сурталчлах, донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд бусдыгаа хошуучлан идэвхтэй оролцсон байгууллага, доноруудыг урамшуулна.

Аян жилийн туршид үргэлжлэх ба 2026 оны 1 дугаар сарын 1-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэж дүнг гаргана.

А/Б тушаалын хоёрдугаар хавсралт

9043446 2020030036

“ ЦУСАА ӨГЧ, ИТГЭЛ ТҮГЭЭЕ - ХАМТДАА АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЕ”

АЯНЫ ТӨСӨВ

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага	
1	Олон улсын донорын Дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх					ЭМГ БОЭТ-ЦСБ Донор хамт олон Байгууллагууд	
	Цусны донорын өдрийн хүндэтгэлийн арга хэмжээ			875,000	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Бүсийн оношлогоо эмчилгээний төв цусны салбар төв , Улаан Загалмайн Хороо,		
	Тэмцээн уралдааны зардал	2	200,000	400,000			
	Гарын бэлэг	50	20,000	1,000,000			
	Цайны зардал	100	2,250	225,000			
Нийт		2,500,000					
2	Тогтмол хугацаанд цусаа бэлэглэдэг донорын урамшуулал	25	20,000	500,000			
3	Доноры байгууллагуудын дунд аст тэмцээны зардал	2	250,000	500,000			
3	Цусны донорын сургалт, сурталчилгаа	400	5,000	2,000,000			
4	Цус бэлэглэхийн өмнө донорын бэлтгэл	600	2,500	3,500,000			
5	Аяны шагнал байгууллагууд болон байнгын доноруудын урамшуулал	Байгууллага				БОЭТ Цусны салбар төв	
		Тэргүүн байр	1	250,000	400,000		
		Дэд байр	1	150,000			
		Байнгын донорууд					100,000
		Байнгын донорууд	10	50,000	500,000		
		Өргөмжлөл	2	50,000			
Нийт дүн 10,000,000							